



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/В

Улаанбаатар хот

Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 62 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/69 дугаар тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах, цус, цусан бүтээгдэхүүний хангамжийг тасралтгүй зохион байгуулах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, үйл ажиллагааны тасралтгүй бэлэн байдлыг хангаж ажиллахыг нийт ажилтан, албан хаагч нарт үүрэг болгосугай.

2. Тохиолдол удирдлагын тогтолцооны үйл ажиллагааг идэвхжүүлж ажиллахыг Төвийн тохиолдлын удирдлагын тогтолцооны штабын нарийн бичгийн дарга (Э.Чагцалдулам), нийт ажилтан албан хаагчдад өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед, гар утсаа нээлттэй байлгах, хүндэтгэх шалтгаанаас бусад тохиолдолд чөлөө олгохгүй болохыг сануулж, цаг ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн менежер (Ч.Жаргалмаа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Нийт ажилтан, албан хаагчдын биеийн болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ хэрэгжүүлэхийг Донор зохион байгуулалтын тасгийн технологич эмч (Б.Одонтунгалаг), Цусны чанар аюулгүй байдлын албаны Халдвар судлаач, Хөдөлмөрийн эрүүл мэнд аюулгүй байдал хариуцсан ажилтан (Э.Чагцалдулам) нарт даалгасугай.

4. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж ажиллах үеийн цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж, шаардлагатай үед ажиллах ажиллагсдын бэлтгэлийг хангуулахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч (Э.Тунгалагтуяа), Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч (Б.Оргил), Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч (М.Цэрэндэжид) нарт тус тус үүрэг болгосугай.

1300010-11

5. Шаардлагатай үед дуудах донорын карт, цус цуглуулах, шинжилгээ хийх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд шаардлагатай оношлуур, хүүдий, багаж хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгслийн тооцоо судалгаа хийж танилцуулах, бэлэн байдлыг хангаж ажиллахыг биостатистикч, эдийн засагч (Ш.Соёлмөнх), аж ахуйн нярав (Д.Буриад), Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч (Э.Тунгалагтуяа), Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч (Б.Оргил), Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч (М.Цэрэндэжид) болон техникийн саатал гарсан үед ажиллуулах нөөц цахилгаан үүсгүүр, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн автомашин, цахим систем, сүлжээ, тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг шалгаж бэлэн байдлыг ханган ажиллахыг Инженер техникийн тасгийн эрхлэгч (Б.Додьгалсан), Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны Эрүүл мэндийн удирдлагын мэдээлэл, технологийн инженер (Ч.Далайцэрэн) нарт тус тус даалгасугай.

6. Төвийн 1, 2 дугаар байрны галын болон шугам, сүлжээний аюулгүй байдлыг шалгаж, гал, усны эрсдэлээс сэргийлэн гэрээт харуул, хамгаалалтын албанд анхааруулж, ажлын байрыг орхихгүй байх сэрэмжлүүлэг өгч, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга (Ч.Батболд), тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нөхцөл байдал авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн яаманд тухай бүр танилцуулахыг дотоод аудитор (С.Алтаннамар) нарт тус тус үүрэг болгосугай

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР